

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар сарын 19-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 62, 64, 65, 67 дугаар зүйлүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 17.00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-19/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам, бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Наранзулыг томилсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга  
Гишүүд



Н.Бүрэнжаргал  
Б.Болормаа  
Г.Алтантуяа

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.НАРАНЗУЛ

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 дугаар сарын 19-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Ногдол ашиг хуваарилахгүй тухай*

“Компанийн тухай хууль”-ийн 46.1 дүгээр зүйл, “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК нь 2020 онд алдагдалтай ажилласан ба банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдэд “2020 оны ногдол ашиг хуваарилахгүй тухай” мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Бүрэнжаргалд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  *Б.Наранзул* Б.НАРАНЗУЛ